

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-11</i>
<hr/>	
<i>1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	<i>3-10</i>
<i>2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>10-11</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 17-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 14 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир;

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ц.Анандбазар, Ц.Туваан, Г.Тэмүүлэн.

Нэг. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Г.Ганболд нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат нар хариулж, тайлбар хийв.

Т.Энхтүвшин: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 16 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 32 минут үргэлжилж, 17 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 70.6 хувийн ирцтэйгээр 16 цаг 46 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Т.ЭНХТҮВШИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
12 цаг 13 минут

ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Т.Энхтүвшин: Байнгын хорооны нийт гишүүд олонх нь хүрэлцэн ирсэн тул Байнгын хорооны ирц бүрдсэн байна. 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдэж байна.

Хуулийн зохицуулалтыг та бүхэндээ уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.2-т Байнгын хорооны хуралдааны дэгийн тухай. Байнгын хороонд харьяалагддаг нийт гишүүний олонх нь хүрэлцэн ирсэн бол түүнийг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэхэд хүчин төгөлдөр ирцтэй гэж үзнэ гэж заасан байж байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдаанд ирсэн гишүүдээ та бүхэндээ танилцуулъя. 8 дугаар тойрог Төмөртоогогийн Энхтүвшин, 14 дүгээр тойрог Жигжидийн Батжаргал, 20 дугаар тойрог Дамбын Батлут, 4 дүгээр тойрог Жадамбын Бат-Эрдэнэ, 20 дугаар тойрог Сайнхүүгийн Ганбаатар, 10 дугаар тойрог Гочоогийн Ганболд, 11 дүгээр тойрог Нанзадын Наранбаатар, 13 дугаар тойрог Жаргалтулгын Эрдэнэбат, 5 дугаар тойрог Шатарбалын Раднаасэд. Нийт ирц 58,8

хувьд хүрсэн учир хуралдаанаа эхлүүлэе ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал нэг. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл Монгол Улсын Засгийн газар 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх.

2 дахь асуудал. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл Монгол Улсын Засгийн газар 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудалтай асуудлын талаа талаар саналтай гишүүд байна уу. Саналтай гишүүд алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх талаар хэлэлцье. Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай. Ажлын хэсгийн гишүүдийг та бүхэндээ танилцуулъя. Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд, Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нинжбатын Ууганбаатар Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор.

Хэлэлцүүлэг эхлэхтэй холбогдуулан хуулийн зарим заалтуудыг та бүхэндээ уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49.1-д

Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ гаргана.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13.2-т бусад Байнгын хороо уг төслийн талаар тус тусын санал, дүгнэлтээ Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж Төрийн байгуулалтын байнгын хороонд өгнө гэж тус тус заасан байдаг.

Хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Ганболд гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн Ганбаатар гишүүний микрофоныг өгөөрэй.

С.Ганбаатар: Би Нийгмийн бодлогын байнгын хороон дээр бас өглөө хэлсэн тэр санаагаа давтах гэж байна. Ер нь бол энэ эрх баригчдыг Засгийн газрыг би юм болгон дээр нь харлуулах юм уу, шүүмжлэх тийм зорилго ерөөсөө тавьдаггүй. Сайн юмыг нь бас дэмжиж, байр сууриа илэрхийлдэг. Оюутолгойн тал дээр өнгөрсөн 20-иод жилийн Засгийн газрууд дотроос хамгийн их ард түмэнтэйгээ ойрхон байсан нь үнэн. Энийг бол хаана ч хэлнэ. Нүүрсний хулгай энэ олон авлига, хулгай дээр бол бас хатуу байсан. Энэ дээр нь бол дэмжээд л явж байгаа. Үндсэн хуулийн асуудал дээр бол би яг өөрийнхөө байр суурь, итгэл үнэмшил дээрээ хатуу байна. Би та нарт нэг л юм хэлж байгаа юм.

Тэр 152 уу, 126 юу, 108 уу, 200 юу, 300 юу би энэ тухай яриагүй. Зүгээр энэ ард түмний яг Үндсэн хуульд байдаг эзнийх нь эрхэд халдчихаад байна л гэдгийг би ганихан хэлж байгаа юм. Энэ Вэндийн хэлсэн үг байдаг л даа. Зөвшилцөл бол фашизм юм гээд хэлж байсан. Яг үг нь бол өөрөө, яг үг нь өөрөө Наваз гэдэг хүнээс авсан үг л дээ. Ард түмэнтэйгээ зөвшилцөхгүйгээр, ард түмэнтэйгээ ойлголцохгүйгээр, эрх

баригч нь хоорондоо зөвшилцвөл фашизм юм гэсэн анх үг гарсан юм л даа. Тэр шиг өнөөдөр ард түмэн 100 хувь орчим эсрэг байхад, хаалгаа хааж байгаад л орж ирээд л, бид зөвшилцөөд л 4-ний 3 байна уу, 4-ний хэд нь ч байдаг юм ингээд дэмжүүлнэ гэдэг бол сайхан зүйл биш ээ.

Би энэ дээр хууль ярья. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйл. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны үндсэн зарчим гэж байгаа юм шүү. Зарчим. 5.1. Улсын Их Хурал хууль санаачлагч нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны бүх үе шатад бүх үе шатад дараах үндсэн зарчмыг баримтална.

1 дүгээр. Үндсэн хуулийг дээдлэн сахих, түүнийг тогтвортой байдлыг хамгаалах. Одоо бол бид тогтворгүй байдал руу оруулах гэж байгаа.

2 дугаарт. 5.1.2 ард түмний бүрэн эрхт байдалд оролцоог хангах. Бид хаалгаа түгжиж авч байгаад одоо энд өөрсдөө шийдэх гэж байгаа.

3 дугаарт. 5.1.3 бодитой, ил тод байх гэж байгаа. Бодитой. Би бол өөрөө мэдрэмжээр бол 99,99 хувь нь л ард түмэн эсрэг байх шиг байх юм. Одоо би буруу ойлгоод байх шиг байна. Та нар маань арай л амьдралаас тасарчхаад байна уу. Тэнд 99 хувь эсрэг байдаг. Энд 99 хувь дэмжээд байдаг. Бид амьдралаас хол байна.

5.4. Улсын Их Хурал хууль санаачлагч нь энэ хуулийн 5.1.3-д заасан зарчмыг доор дурдсан үндсэн арга замаар хангана гэж байгаа юм.

5.4.6. Би энэ олон юмыг нь яриад яах вэ. Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо ажиллаж, үйл ажиллагааны үр дүнг мэдээлж, иргэдийн санал бодлыг харгалзан үзэх гэж үг байгаа шүү одоо. Тэгэхээр энэ өөрчлөлт оруулах журмын тухай хуульд ингэж зарчмууд заасан

байна. Миний хэлэх гэж байгаа зүйл гэвэл, та нараас хүсэх гэж байгаа зүйл гэвэл 126-г 125 болгооч гэж би гуйх гээгүй. Энэ тоон дээр би буруу, зөв гэж ярих гээгүй. Ганцхан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 17.1 дэх хэсэгт Улсын Их Хурал төслийг энэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар хэлэлцээд тухайн нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар оруулах нь зүйтэй гэж Улсын Их Хурлын нийт гишүүний 3-ны 2-оос доошгүй нь саналаар тогтвол ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоол гаргана гэж заасан байгаа. Яг энэ үүднээсээ би 3 Байнгын хороонд харьяалагддаг. 3 Байнгын хорооноосоо би гуйх, хүсэх юм бол та бүхэн маань энийг Төрийн байгуулалтын байнгын хороогоор дамжуулж, Улсын Их Хуралд энэ 3-ны 2-оос доошгүй нь саналаар тогтох энэ санал асуулгыг асуугаад өгөөч гэдэг энэ саналыг би Байнгын хороогоороо дамжуулж, Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хуралдаа оруулахыг хүсэж байна. Миний саналыг дэмжих боломж байгаа юу.

Т.Энхтүвшин: Нямбаатар сайд ороод ирлээ. Ажлын хэсэг. Ажлын хэсгээс хэн хариулах вэ. Ажлын хэсэг хариулахаас өмнө бас нэг хуулийн заалтыг уншаад танилцуулчихъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан байна. 46.4-д Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдааныг хэлэлцэхэд гишүүдийн асуулт асуух хугацаа 8 минутаас илүүгүй, нэмэлт асуух хугацаа 2 минутаас илүүгүй. Гишүүдийн асуултад хариулт хариулах хугацаа 8 минутаас илүүгүй, нэмэлт хариулт тайлбар авах хугацаа 1 минутаас илүүгүй гэж заасан байна.

49.2-т Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчаас асуулт асууж болно гэж заасан байна. Нямбаатар гишүүний микрофоныг өгье.

Х.Нямбаатар: Түүрүүн Ганбаатар гишүүн бид 2 бас нэг Байнгын хороон дээр яг энэ асуудлаар ярилцсан. Би Нийгмийн бодлогын байнгын хороон дээр санаж байна. Тэгэхээр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах 2 үндсэн аргыг Монгол Улсын Үндсэн хуульд хуульчилсан.

Нэгд нь. Ард нийтийн санал асуулга явуулах замаар ард нийтийн санал асуулгын дүнг Улсын Их Хурал баталгаажуулж, ёсчлох замаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Нөгөөх нь болохоор Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль санаачлах эрх бүхий субъект Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачилж, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд заасны дагуу хэлэлцүүлгүүдийг мөн цаашилаад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн тэр хязгаарлалтын хүрээнд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах процессын ажиллагаа явагдаад, Улсын Их Хурлын гишүүдийн 57-оос дээших саналаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм 2 үндэс арга хэрэг хэрэгсэл бий.

Ард нийтийн санал асуулгын тухай хуулийг 2016 онд шинээр дахиж баталсан байгаа. Энэ Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 5 дугаар зүйлд санал асуулгыг санаачлах эрх бүхий этгээдэд Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурлын гишүүн, нийт гишүүний 3-ны 1-ээс доошгүй нь санаачлах эрхтэй гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл 25-аас дээш гишүүд Ард нийтийн санал асуулга явуулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачилж, Ард нийтийн санал асуулга явуулах тухай хуульд заасан журмын дагуу ард нийтийн санал асуулгыг явуулаад, санал асуулгын дүнгээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм процесс явагдана.

Тэгэхээр Үйлдвэржилтийн байнгын хорооны гишүүдэд эргэж нөгөө энэ удаагийн Үндсэн хуульд нэмэлт оруулах төслийн процессыг би эргээд нэг ганцхан минутад товчхон хэлье гэж бодож байгаа юм.

Хэдүүлээ 1 дүгээрт энэ төслийг хэлэлцэж байх үед энэ бол Үндсэн хуульд нэмэлт оруулах төсөл. Өөрөөр хэлбэл нэмэлт, өөрчлөлтийн төсөл биш. Нэмэлт оруулах төсөл байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2022 онд Үндсэн хуулийн цэцийн 01, 02 дугаарт дүгнэлт гаргасан. Энэ дүгнэлтээр Монгол Улсын Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа хууль санаачлах эрх бүхий этгээдээр уламжилж, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм Үндсэн хуулийн эрх зүйн үүд хаалга нээгдсэн гэж товчхондоо хэлж болно. Энэ 2 дүгнэлтэд ямар 2 асуудал туссан бэ гэхээр 1 дүгээрт, Улсын Их Хурлын гишүүдийн тоог эргэн харах, түүнтэй холбоотой нэмэлтийг боловсруулах,

2 дахь зүйл нь болохоор сонгуулийн шинэлэг тогтолцоог оруулж ирэх энэ боломжийг судалж оруулаач гэдэг ийм утга агуулга бүхий дүгнэлтүүд гарсан. Үүний дараа 2022 онд Улсын Их Хурал 34, 54 гэдэг 2 тогтоол гарсан. 54 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газарт Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй уялдуулж Үндсэн хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулахыг даалгасан. Энэ 54 дүгээр тогтоолын дагуу Засгийн газар дээр ажлын хэсэг байгуулагдаад, ажлын хэсгээс одоогийн бидний өргөн барьж байгаа Үндсэн хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн барьж байгаа юм. Гишүүд, зарим хүмүүс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг хэрхэн харж байна гэдэг ийм асуудлыг өмнөх Байнгын хороо дээр асууж байна лээ. Үндсэн

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар 3 төрлийн том хязгаарлалт байдаг. Яг нөгөө Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах агуулга талаасаа.

Нэг нь, Ерөнхийлөгч өөрийнхөө эрх хэмжээтэй холбоотой асуудлаар хуулийн төсөл санаачлах эрхгүй,

2 дугаарт Улсын Их хурал өөрийнхөө эрх хэмжээтэй холбоотой асуудлаар хуулийн төсөл санаачлах эрхгүй,

3-д Засгийн газар өөрийнхөө эрх хэмжээтэй холбоотой асуудлаар хуулийн төсөл санаачлах эрхгүй гэсэн ийм хязгаарлалт байгаа. Дээр нь ямар хязгаарлалт байдаг вэ гэвэл уг асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулснаас хойш 8 жилийн хугацаанд уг асуудлаар дахин 8 жилийн дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар хуулийн төсөл санаачлахыг хязгаарладаг.

Дээр нь 5 дахь хязгаарлалт нь юу байдаг вэ гэвэл нийт Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн агуулгын хүрээ хязгаар нь түүний 33 хувиас хэтэрсэн тохиолдолд энэ өөрчлөлтийг шинэчилсэн найруулга гэж үзнэ гэсэн ийм агуулгууд байгаа юм. Тэгэхээр өнөөдрийн Засгийн газраас өргөн барьж байгаа төсөл нь Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуулийн 68.2-т заасан тэр үндэслэлийг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Засгийн газраас санаачилж, оруулж ирж байгаа төсөл юм.

2 дугаарт миний хэлэх гэж байгаа үг бол бас Их Хурлын гишүүд тойрогт иргэд, олон нийттэй уулзахад, мөн парламент дахь сөрөг хүчний төлөөллүүд юу гэж үзэж байгаа вэ гэвэл нэг удаа өөрчлөлт оруулахдаа хэдүүлээ дорвитой өөрчлөлт оруулбал яасан юм бэ гэдэг агуулгыг тавьдаг. Засгийн газрын тэргүүн юу гэж үзсэн бэ гэхээр энэ удаагийн нэмэлт бол 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн үргэлжлэл юм. 2019 онд яг

энэ асуудлаар санал хураалт явагдахын өмнө ажлын хэсэг дээр зарчмын зөрүүтэй саналууд гарч ирээд энэ асуудлыг хурааж чадаагүй юм. Тэгэхээр энэ бол 2019 оны өөрчлөлт юм. Энэ удаагийн өөрчлөлтөөр бид нар ийм тоо, тогтолцоог хөндөж, нийгмийн олон бүлгүүдийн төлөөлөлтэйгөөр Үндсэн хуулийн шинэ реформыг эхлүүлэв. Цаашид 2024 онд шинээр байгуулагдах энэ хууль батлагдсаны дараа шинэ байгуулагдах парламент нь нийгмийн бүлэг, сегментүүдийн төлөөлөлтэй, өргөн бүрэлдэхүүнтэй орж ирж байж, нийгмийн гэрээгээ цаашид гүнзгийрүүлэн шинэчлэх үү, эс үгүй бол энэ хэвээрээ цаашид хэсэг хугацаандаа явах уу гэдгээ шийдэх нь зөв зүйтэй. Нэг нам үнэмлэхүй олонхыг бүрдүүлж байгаа энэ үед нийгмийн гэрээгээ олон талаас нь хөндөх нь энэ өөрчлөлтийнхөө легитим тэр шинэ чанарыг алдагдуулна гэдэг ийм байр суурьтайгаар зөвхөн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын хүрээнд хууль санаачлагч оруулж ирж байгаа. Ганбаатар гишүүний хэлж байгаачлан энэ эрх бол танд нээлттэй байгаа. Ганбаатар гишүүн та Ард нийтийн санал асуулгын тухай хуульд заасны дагуу ард нийтийн санал асуулга явуулах тогтоолын төслийг Их Хурлын нийт гишүүдийн 3-ны 1-ээс доошгүйн гарын үсгийг цуглуулж чадсан тохиолдолд парламент уг асуудлыг шууд авч хэлэлцэх ийм хуулийн зохицуулалттай гэдгийг би бас нэмж хэлэв. Баярлалаа.

Т.Энхтүвшин: Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Ард нийтийн санал асуулгын тэгвэл тэр журмынхаа тухай хуулиар 25 гишүүнээс дээш гарын үсэг зураад ингээд санаачлах юм байна. Тэгэхээр энэ дээр зүгээр тодруулахад ер нь энэ чинь ингээд л маргааш нөгөөдөргүй хэлэлцэхээс өмнө нь шийднэ гэсэн үг биз дээ? Тийм ээ. Хугацааны хувьд ямархуу боломж байгаа билээ. Энэ чинь маргааш, нөгөөдөр орох билүү. Би

зүгээр хэтэрхий техникийн юм асуучихлаа шүү.

Т.Энхтүвшин: Нямбаатар сайдын микрофоныг өгөөрэй.

Х.Нямбаатар: Өнөөдрийн Байнгын хорооны хурал бол Үндсэн хуулийн нэмэлтийн төслийг 2 дугаар хэлэлцүүлэгт бэлтгэхтэй холбоотой бүх Байнгын хороод хуралдаж байгаа. Би түүрүүн хэлсэн яг энэтэй уялдаж, яг энэ зарчмын зөрүүтэй санал гаргаад, ард нийтийн санал асуулга явуулах асуудал бол яг энэ хэлэлцүүлэг, энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дэгтэй холбоотой. Уялдахгүй гэж би бол байр сууриа илэрхийлэх байна. Энэ дээр Тамгын газар Үнэнбат дарга тодруулга хийх нь зөв байх. Яагаад гэвэл Ганбаатар гишүүн энэ 2 байнгын хороо дээр яг энэ асуудлыг ярьж байгаа учраас Байнгын хорооны дарга аа, Үнэнбат даргаар нэг тодруулга хийлгэе гэж бодож байна. Ард нийтийн санал асуулга явуулах тэр тогтоолын төсөл санаачлах эрх бол хууль санаачлах эрх бүхий субъектэд бүгдэд нь хадгалагдаж байгаа. Би түүрүүн уншиж сонсгосон. Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн.../минут дуусав/

Т.Энхтүвшин: Үнэнбат дарга тодруулга хийх үү. Үнэнбат даргын микрофоныг өгөөрэй. Товчхон.

М.Үнэнбат: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Үндсэн хуулийн 68 дугаар зүйл буюу 6 дугаар бүлэг. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал гэж байгаа. Тэгээд 68 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн 3-ны 2-оос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна гэсэн ийм зохицуулалттай байна.

Т.Энхтүвшин: Гочоогийн
Ганболд.

Г.Ганболд: Бид нар Үндсэн хуулийн өөрчлөлтийн 2 дугаар хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороо хуралдаж байна л даа. Тэгээд би энэ хурал нь жоохон процессын л алдаатай яваад байна. Жишээлэх юм бол энэ ажлын хэсэг чинь Засгийн газрын ажлын хэсэг байна шүү дээ. Засгийн газрын ажлын хэсгээс бид нар хэлэлцэх эсэхийг, 1 дүгээр хэлэлцүүлгийг бүгдийг нь асуучихсан. Яагаад 152 гэж оруулж ирсэн юм гээд л. Тэгээд л куб язгуурын аргаар, бусад Дэлхийн улс орнуудын жишгээр гээд л. 3 сая 400 мянган иргэнээс язгуураас гаргахаар 152. 152-ын куб зэрэгт дэвшүүлэхээр 3 сая 400 мянга гээд л. Тэгээд одоо бид нар энэ хүмүүсээс дахиж асуух юм байхгүй шүү дээ. Одоо би ойлгож байгаагаар энийг чинь хэлэлцэх эсэх нь гараад Их Хурлаас ажлын хэсэг байгуулагдсан. Их хурлын ажлын хэсэг нь бол би Нямаагийн Энхболд даргаар ахлуулсан ажлын хэсэг гэж би ойлгож байгаа. Тэр ажлын хэсэг дээр яг ямар шийдвэр гаргасан юм бэ. Одоо бид нар бол улс төрийн намуудын дарга нарын зөвшилцлийн нэг юм яваад байх юм. Тэрийг бид нар энд хэлэлцэх ёсгүй шүү дээ. Тэрийг яг Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсэг нь хэлэлцээд, яг 126 гэж оруулж ирсэн юм бол хэд нь мажоритар, хэд нь пропорциональ, яагаад. Тэгээд энийг бид нар өнөөдөр асууж Төрийн байгуулалтын байнгын хороо руу Байнгын хороо саналаа хураах ёстой шүү дээ. Тэгж байж санал хурааж байж нэгдсэн чуулган руу орох ёстой байхгүй юу. Бид нар хэрэвзээ 76 мажоритар гэж байгаа бол яагаад 77 болгож болохгүй гэж. Энэ Өмнөговь аймаг гээд л газар нутаг томтой 2 гишүүнтэй нэммээр байна гэсэн аймгууд байдаг шүү дээ. Тэгээд энийг бид нар бол уг нь яг тэр 126 гэж тогтоож байгаа юм бол тэр хүрээндээ ажлын хэсэг дээр яг яаж ярьсан юм. Тийм боломж байгаа юм уу. Мажоритар, холимог тогтолцоогоо бид нар 70/30 юм уу 60/40 юм уу

гэдгийгээ яг яаж ярьсан юм. Энэ хүрээнд чинь энэ Байнгын хороо чинь саналаа хураагаад Төрийн байгуулалтын байнгын хороо руу тодорхой саналуудаа тэрийг нь дагаж ярьж байж оруулах ёстой биз дээ. Тэгж байж Төрийн байгуулалтын байнгын хороо санал, дүгнэлтээ гаргаж нэгдсэн чуулганд оруулах ёстой шүү дээ. Тэгэхээр бид нар чинь одоо шууд ингээд хэлэлцээд явах юм бол Засгийн газрын оруулж ирсэн Засгийн газрын ажлын хэсэг 152-ыг ярих гээд байна шүү дээ. Тэгэхээр бид нар эсвэл гишүүд чөлөөтэй яриад ингээд 108, 120, 123, 126 гээд ярих юм уу. Эсвэл ажлын хэсгийн 1 тоон дээр тойрч ярих юм уу. Энийгээ жоохон тодорхой болгохгүй бол түрүүн бид нар Хөдөө аж ахуйн байнгын хороон дээр ороод, юу ч ойлгоогүй ингээд л пад гээд л дууслаа. Гэтэл одоо энэ нийгэм чинь Байнгын хорооны гишүүд нь 100 хувийн саналаар л 152-ыг дэмжиж байгаа юм шиг ойлгох гээд байна шүү дээ. Энийг тэгээд яаж явах юм. Их Хурлын ажлын хэсэг нь яг хуралдсан юм уу, хуралдаагүй юм уу. Тийм шийдвэр тэр намын дарга нарын гаргасан шийдвэрийг ажлын хэсэг нь дэмжсэн юм уу. Одоо бид нар бол Байнгын хороо дээр зөвхөн ажлын хэсгийн л саналыг ярина шүү дээ. Түүнээс улс төрийн намуудын саналыг бид нар ярих эрхгүй шүү дээ. Тэгэхээр ажлын хэсгийн саналыг ярьж, тойрч ярьж, тэр дээрээ жинхэнэ тоо дээрээ, холимог дээрээ, хувь дээрээ ярьж саналаа оруулах ёстой юм биш үү,

Т.Энхтүвшин: Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Би Ганболд гишүүний асуултад товчхон хариулъя. Өнөө өглөө 9 цагаас ажлын хэсэг хуралдсан. Ажлын хэсэг дээр улс төрийн намуудын зөвшилцлийн асуудал өнөөдөр шийдэгдэх байх. Тэр болтол Байнгын хороод дээр нөгөө өргөн барьсан төслийнхөө хүрээнд хэлэлцүүлэгт бэлтгэх ийм хэлэлцүүлгүүдийг Байнгын хороодод зохион байгуулъя гэдэг ийм байр суурь дээр ажлын хэсэг хүрсэн. 9 цагт хуралдсаны дараа 11 цагаас

парламентад суудалтай улс төрийн намуудын зөвшилцөл хийгдсэн гэж ойлгож байгаа. Би өөрөө улс төрийн тэр намуудын зөвшилцөх ажлын хэсэгт байхгүй. Би Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсгийн гишүүн. Нямаагийн Энхболд дарга ахалж байгаа. Өнөө өглөө бараг 100 хувийн ирцтэй ажлын хэсэг хуралдаад, хөдөө орон нутгуудад, тойрог дээр иргэд, сонгогчид ажилласан байдал, улс төрийн намын бүлгүүдийн байр сууриудыг ярилцаад, Үндсэн хуулийн өөрчлөлт гэдэг бол энэ зөвшилцөл дунд хийгдэх ёстой учраас энэ улс төрийн намуудын удирдлагуудын зөвшилцлийг хараад, дахиж ажлын хэсэг хуралдъя гэдэг ийм байдалтайгаар өнөөдөр хурал өндөрлөсөн. Маргааш өглөө ажлын хэсэг хуралдана. Ажлын хэсэг хуралдсаны дараа Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдана. Төрийн байгуулалтын байнгын хороо дээр миний ойлгож байгаагаар бол өнөөдрийн зөвшилцлийн үр дүнгээр зарчмын зөрүүтэй саналын томъёолол боловсруулагдах болов уу гэдэг байр суурьтай байна. Улс төрийн намууд 126 гэдэг тоон дээр хэвлэл мэдээлэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл 11 цагаас хийх шиг болсон. Энэ дээр ямар байр суурь тоо тохирч байгаа вэ гэхээр 1 дүгээрт сөрөг хүчин Ардчилсан нам бол мажоритар, пропорционалийн харьцааг 40/60-ын харьцаатай байя. 130 хэд гэлээ 135 гэдэг саналаа ирүүлсэн. Үүний дараа өчигдөр манай намын бүлэг бас хуралдсан. Манай намын бүлэг дээр бас энэ асуудлаар ярьсныг бол та бүхэн мэдэж байгаа. Тэгээд 126 гэдэг энэ тоо бол тойргийн 76 өнөөгийн хадгалж байгаа орон нутаг, орон нутгийн хөгжлийн бас энэ онцлог тархай бутархай газар нутаг өргөнтэй энэ байдлыг харгалзаж, мажоритарынхаа тоог хадгалж үлдэх нь зүйтэй. 76 гэдэг. Үүн дээр нэмээд нийгмийн бүлэг, сегментүүдийн төлөөлөл, эрдэмтэн, судлаачдын төлөөлөл жагсаалтаар орж ирэх энэ боломжийг хангаж 76/50 буюу 126. Үүнийг ингээд хувилаад үзэхээр 39,5 хувь нь пропорциональ, 60,5% нь мажоритар

буюу Ардчилсан намын тавьж байгаа 60/40 гэдэг энэ харьцаан дээр ер нь очиж байгаа. Тэгээд иргэд, сонгогчид 120 гэдэг, 20 хэд гэдэг тоон дээр байвал яадаг юм бэ гэдэг саналууд сая тойрог, орон нутагт 108-120 гэдэг тоон дээр илүү их саналууд гарч ирсэн учраас энэ зөвшилцөл рүү явбал яасан юм бэ гэдэг ийм зөвшилцөлд хүрсэн гэдгийг би бас намын бүлгийн даргатай уулзаж энэ талын мэдээллийг авсан.

Т.Энхтүвшин: Ганболд гишүүн.

Г.Ганболд: Харин тийм. Тэгэхээр тэрийгээ нөгөө ажлын хэсэг чинь нэг цаасан дээр буулгаж, орж ирэхгүй юм уу. Байнгын хороон дээр. Тэгээд асуумаар байх юм. Яагаад тэгж шийдсэн юм, харьцаа нь яагаад тийм болсон юм. Аль нэгийг нь мажоритарын ч юм уу пропорционалийг нь нэмж болохгүй юм уу, нэмэх юм уу гээд ингээд ажлын хэсгээс асууж, ажлын хэсэг чинь яг энэ дээр оруулж ирж бид нар чинь тэр асуудлыг чинь дэмжих, дэмжихгүйгээ явуулмаар санагдаад байгаа юм. Тэгэхэд чинь бид нар чинь юу хэлэлцэх гэж байгаа нь ойлгомжгүй байна шүү. Хэлэлцэх юмгүй суугаад байна шүү дээ. Одоо яг ингээд манай Байнгын хороонд чинь.

Тэгвэл наадах чинь дэг чинь худлаа байна шүү дээ. Юу гэж тэгж байдаг юм. Бид нар өмнөх хороод дээр хуралдахаар чинь бид нар ажлын хэсэг л Байнгын хороон дээр санал, дүгнэлтээ оруулж ирж байна шүү дээ. Тэрийг тойрч ярина уу гэхээс, оруулж ирээгүй байхад нь өмнөх оруулж ирсэн хүмүүстээ. Бид нар эд нартай юу ярих юм. Эд нар чинь 152-ыг л оруулж ирсэн хүмүүс шүү дээ. Одоо энийг буулгасан хүмүүсийнх нь санаа бодлыг хэд болгочоод байгаа юм. Тэрийг нь бид нар ингээд ярих, тэгээд тэрэн дээр нь санал, дүгнэлтээ гаргах ёстой болохоос биш одоо бид нар яг юу хэлэлцэх гэж байгаа нь л ойлгомжгүй болчихоод байна. Үгүй ээ, төсөлгүй хэлэлцчихсэн шүү дээ.

Т.Энхтүвшин: Ганболд гишүүн ээ, өчигдөр бас энэ дээр даргын дэргэдэх зөвлөл хуралдсан. Дэгийн тухай хууль дээр энэ Үндсэн хуультай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн асуудал бол Байнгын хороогоор эхэлж орох ёстой юм байна лээ. Дараа нь юу гэдэг юм Төрийн байгуулалтын байнгын хороогоор эцэслэгдээд ингэж явахаар Дэгийн тухай хууль дээр байгаа юм байна лээ. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Санал хураалтаас өмнө бас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг бас танилцуулъя. 49.2 дахь хэсэгт Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчаас асуулт асууж, саналаа урьдчилан бичгээр томъёолж хуралдаан даргалагчид өгсний үндсэн дээр түүнийгээ үндэслэн тайлбарлан 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлж, санал хураалгах эрхтэй гэсэн ийм заалт байж байгаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаар саналтай гишүүн байна уу. Санал байхгүй юм байна. Ер нь гишүүд бол заавал юу гэдэг юм бичгээр саналаа ирүүлсэн байх ёстой. Саналтай гишүүд алга байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн 2 дахь хэлэлцүүлэгт оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтын дүнг танилцуулъя. Нийт оролцсон гишүүний 83,3 хувь нь дэмжсэн байна.

16.43 цаг.

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан санал гаргах гишүүд нэрээ өгнө үү. Гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Асуулт асуух гишүүн байхгүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан санал гарах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Асуулт асуух гишүүн байхгүй байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан санал гаргах гишүүд байна уу. Санал гаргах гишүүд байхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөх мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна.

Гишүүд болон ажлын хэсэгт баярлалаа. Энэ өдрийн хуралдаанд хэлэлцэх асуудал дууссан тул Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хурал дууссаныг мэдэгдье ээ.

16.46 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ